



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/657

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.10 дахь заалтууд, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүү бүртгэлийн алба үүсч хөгжсөний 113 жилийн ой, санхүүчдын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд аймгийн бүртгэл, санхүүгийн байгууллагын ажилтнуудын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг спортын уралдааныг хөгжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, эв нэгдлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Арга хэмжээний зардалд шаардагдах 9.000.000 /есөн сая/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж, үр дүнг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор тайлагнахыг аймгийн Татварын газрын дарга (Н.Энхтуяа)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Л.Хаш-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын
20... оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар захирамжийн
хавсралт

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН АЛБАН ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ
113 ЖИЛИЙН ОЙ, САНХҮҮЧДЫН БАЯРЫГ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ

Д/д	Зохион байгуулах арга хэмжээ	Мөнгөн дүн
1	Санхүү бүртгэлийн албан үүсч хөгжсөний 113 жилийн ой, санхүүчдын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний зардал	7.000.000
2	Шилдэг нягтлан бодогч нарыг алдаршуулах	2.000.000
3	Нийт дүн	9.000.000

__оОо__